



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 3/0526

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө хэлэлцэх тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн стратеги төлөвлөгөөний шинэчилсэн төслийг удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж, төсөлд тусгах шаардлагатай холбогдох саналуудыг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
2. Удирдах зөвлөлийн гишүүдэд стратеги төлөвлөгөөний төсөл, холбогдох танилцуулга материал хүргүүлэхийг Удирдах зөвлөлийн нарийн бичиг /Б.Жавхлан/-д даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН